



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аймгийн Прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **ӨВА-2025/113/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум

2025 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: П.Хорлоосүрэн

Утас: 70323108 Цахим хаяг: Khorloosuren@audit.gov.mn

Аудитор: Р.Цэрэндолгор

Утас: 70323108 Цахим хаяг: Tserendolgor@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЗГХЭГ	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар
ХХОАТ	Хувь Хүний Орлогын Албан Татвар
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч

1.Хараат бус аудиторын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173.
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025. 01. 17. № 32
танай _____ -ны № _____ -т

АЙМГИЙН ПРОКУРОРЫН ТАМГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Т.ГАНБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өвөрхангай аймгийн Прокурорын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Прокурорын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд улсын төсвөөс 1,393.4 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулснаас 73.5 хувь буюу 1,023.9 сая төгрөгийг цалингийн зардалд зарцуулжээ. Жилийн эцсээр зарцуулагдаагүй төсвийн үлдэгдэл 73.3 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн. Мөн 100.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж бүртгэлд тусгасны 98.8 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр, 1.5 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бараа материалын тайлан, санхүүгийн тайлан хоорондох уялдаа, эд хариуцагчийн тайланд тавих хяналтыг сайжруулах, байцаан шийтгэх үйл ажиллагааны зардлын жилийн төлөвлөгөө гарган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

15030200

D:\Auditin gazar\baiguullagin dotood barimt\A4

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	39,857,900.00	46,759,690.00
35	БАРАА МАТЕРИАЛ	39,857,900.00	46,759,690.00
354	Хангамжийн материал	39,857,900.00	46,759,690.00
35410	Бичиг хэргийн материал	6,764,700.00	6,764,700.00
35420	Аж ахуйн материал	17,627,200.00	20,337,200.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	3,000,000.00
35450	Барилгын засварын материал	200,000.00	200,000.00
35470	Бусад хангамжийн материал	15,266,000.00	16,457,790.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,135,548,470.78	3,131,284,624.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,135,548,470.78	3,131,284,624.63
392	Биет хөрөнгө	3,092,032,470.78	3,088,098,624.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,979,292,529.00	2,979,292,529.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-58,556,395.89	-112,329,603.33
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,000,000.00	33,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-15,000,000.00	-2,200,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	175,697,433.46	191,268,633.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	-64,105,939.94	-96,488,423.13
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	108,431,373.76	153,597,170.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	-48,726,529.61	-58,041,682.13
393	Биет бус хөрөнгө	43,516,000.00	43,186,000.00
39301	Програм хангамж	1,485,000.00	1,485,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-165,000.00	-495,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	42,196,000.00	42,196,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,175,406,370.78	3,178,044,314.63
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,175,406,370.78	3,178,044,314.63
51	Засгийн газрын хувь оролцоо	3,175,406,370.78	3,178,044,314.63
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	262,115,349.75	262,115,349.75
51101	Өмч: - төрийн	262,115,349.75	262,115,349.75
512	Хуримтлагдсан үр дүн	2,763,822,507.59	2,766,460,451.44
51210	Өмнөх үеийн үр дүн	2,763,822,507.59	2,763,822,507.59
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	2,637,943.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	149,468,513.44	149,468,513.44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,175,406,370.78	3,178,044,314.63

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,588,704,469.00	1,505,052,569.00

Өвөрхангай аймгийн Прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,692,713,569.00	111,623,169.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,692,713,569.00	111,623,169.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,692,713,569.00	99,196,587.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	2,583,590.00
120006	Газрын тосны орлого		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	895,990,900.00	1,393,429,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	885,990,900.00	1,369,353,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	885,990,900.00	1,369,353,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,000,000.00	24,076,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	24,076,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	891,046,938.93	1,488,179,833.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	891,046,938.93	1,487,720,243.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	877,220,288.44	1,409,935,895.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	628,661,697.61	1,023,961,623.00
210101	Үндсэн цалин	359,483,292.00	589,202,356.00
210102	Нэмэгдэл	184,013,554.61	298,144,899.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,599,406.00	61,216,463.00
210104	Урамшуулал	55,565,445.00	75,397,905.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,795,871.64	128,157,973.51
210201	Тэтгэврийн даатгал	52,850,202.99	87,096,776.31
210202	Тэтгэмжийн даатгал	5,157,533.09	10,265,299.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,267,687.76	5,132,649.86
210204	Ажилгүйдлийн даатгал	1,221,231.69	5,132,649.86
210205	Эрүүл мэндийн даатгал	11,299,216.11	20,530,598.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,849,660.20	57,604,729.80
210301	Гэрэл, цахилгаан	3,959,077.00	3,501,274.00
210302	Түлш, халаалт	40,436,825.20	50,845,475.80
210303	Цэвэр, бохир ус	2,453,758.00	3,257,980.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,263,456.06	37,691,264.21
210401	Бичиг хэрэг	11,462,000.00	13,753,900.00
210402	Тээвэр, шатахуун	12,739,200.00	15,999,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,341,056.06	2,992,824.21
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	317,100.00	84,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,404,100.00	4,860,840.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,662,400.00	13,334,700.00
210604	Урсгал засвар	2,662,400.00	13,334,700.00
2107	Томилолт, зочны зардал	11,848,900.00	8,478,400.00
210702	Дотоод албан томилолт	11,848,900.00	8,478,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,000,164.00	15,378,562.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,672,200.00	15,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	45,964.00	96,194.00

Өвөрхангай аймгийн Прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	260,000.00	260,368.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,138,138.93	125,328,643.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,250,000.00	8,496,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	15,291,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	63,888,138.93	101,540,843.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,826,650.49	77,784,347.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,884,226.00	4,620,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,884,226.00	4,620,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,942,424.49	73,164,347.48
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	459,590.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	459,590.00
224001	Стратегийн нөөц хөрөнгө		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,697,657,530.07	16,872,735.85
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	24,658,333.42	14,234,792.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	459,590.00
225006	Гадаадын төслийн зээлээс санхүүжих дамжуулан зээлдүүлэх		
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-24,658,333.42	-14,234,792.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,672,999,196.65	2,637,943.85

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	895,990,900.00	1,393,429,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	895,990,900.00	1,393,429,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	885,990,900.00	1,369,353,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	885,990,900.00	1,369,353,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,000,000.00	24,076,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	24,076,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	840,808,000.00	1,391,889,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	840,808,000.00	1,391,889,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	825,633,849.51	1,314,105,052.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	628,118,457.75	1,023,961,623.00
210101	Үндсэн цалин	352,373,947.00	589,202,356.00
210102	Нэмэгдэл	190,579,659.75	298,144,899.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,599,406.00	61,216,463.00
210104	Урамшуулал	55,565,445.00	75,397,905.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,339,111.50	128,157,973.51
210201	Тэтгэврийн даатгал	51,907,625.02	87,096,776.31
210202	Тэтгэмжийн даатгал	6,110,708.22	10,265,299.16

Өвөрхангай аймгийн Прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210203	ҮОМШӨ-ний даатгал	4,888,566.45	5,132,649.86
210204	Ажилгүйдлийн даатгал	1,210,776.77	5,132,649.86
210205	Эрүүл мэндийн даатгал	12,221,435.04	20,530,598.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,849,660.20	57,604,729.80
210301	Гэрэл, цахилгаан	3,959,077.00	3,501,274.00
210302	Түлш, халаалт	40,436,825.20	50,845,475.80
210303	Цэвэр, бохир ус	2,453,758.00	3,257,980.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,099,756.06	37,691,264.21
210401	Бичиг хэрэг	11,604,100.00	13,701,300.00
210402	Тээвэр, шатахуун	12,372,300.00	15,999,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,344,356.06	3,045,424.21
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	684,000.00	84,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,095,000.00	4,860,840.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,729,000.00	16,334,700.00
210604	Урсгал засвар	11,729,000.00	16,334,700.00
2107	Томилолт, зочны зардал	11,601,400.00	8,478,400.00
210702	Дотоод албан томилолт	11,601,400.00	8,478,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,377,964.00	15,378,562.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,050,000.00	15,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	45,964.00	96,194.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	260,000.00	260,368.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,518,500.00	26,497,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,518,500.00	11,206,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	01.00	15,291,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,174,150.49	77,784,347.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,231,726.00	4,620,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,231,726.00	4,620,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,942,424.49	73,164,347.48
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	55,182,900.00	1,540,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	55,182,900.00	1,540,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	55,182,900.00	1,540,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	55,182,900.00	1,540,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	55,182,900.00	1,540,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-55,182,900.00	-1,540,000.00

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	262,115,349.75	149,468,513.44	2,763,822,507.59	3,175,406,370.78
2	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	262,115,349.75	149,468,513.44	2,763,822,507.59	3,175,406,370.78
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	262,115,349.75	149,468,513.44	2,763,822,507.59	3,175,406,370.78
8	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,637,943.85	2,637,943.85
9	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	262,115,349.75	149,468,513.44	2,766,460,451.44	3,178,044,314.63

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	ЗГСУМС гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,369,353,400.00	1,296,189,052.52	1,296,189,052.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,369,353,400.00	1,296,189,052.52	1,296,189,052.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,364,733,400.00	1,291,569,052.52	1,291,569,052.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,080,959,300.00	1,023,961,623.00	1,023,961,623.00
210101	Үндсэн цалин	596,564,100.00	589,202,356.00	589,202,356.00
210102	Нэмэгдэл	314,700,600.00	298,144,899.00	298,144,899.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	76,065,600.00	61,216,463.00	61,216,463.00
210104	Урамшуулал	93,629,000.00	75,397,905.00	75,397,905.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	135,119,900.00	128,157,973.51	128,157,973.51
210201	Тэтгэврийн даатгал	91,881,500.00	87,096,776.31	87,096,776.31
210202	Тэтгэмжийн даатгал	10,809,600.00	10,265,299.16	10,265,299.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,404,800.00	5,132,649.86	5,132,649.86
210204	Ажилгүйдлийн даатгал	5,404,800.00	5,132,649.86	5,132,649.86
210205	Эрүүл мэндийн даатгал	21,619,200.00	20,530,598.32	20,530,598.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,446,800.00	57,604,729.80	57,604,729.80
210301	Гэрэл, цахилгаан	7,502,000.00	3,501,274.00	3,501,274.00
210302	Түлш, халаалт	55,344,800.00	50,845,475.80	50,845,475.80
210303	Цэвэр, бохир ус	3,600,000.00	3,257,980.00	3,257,980.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,691,600.00	37,691,264.21	37,691,264.21

Өвөрхангай аймгийн Прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210401	Бичиг хэрэг	12,200,000.00	13,701,300.00	13,701,300.00
210402	Тээвэр, шатахуун	15,944,100.00	15,999,700.00	15,999,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,947,500.00	3,045,424.21	3,045,424.21
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,000.00	84,000.00	84,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,800,000.00	4,860,840.00	4,860,840.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,360,000.00	11,334,700.00	11,334,700.00
210604	Урсгал засвар	11,360,000.00	11,334,700.00	11,334,700.00
2107	Томилолт, зочны зардал	8,480,000.00	8,478,400.00	8,478,400.00
210702	Дотоод албан томилолт	8,480,000.00	8,478,400.00	8,478,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,713,000.00	10,378,562.00	10,378,562.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,000,000.00	10,000,000.00	10,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	247,000.00	96,194.00	96,194.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	422,000.00	260,368.00	260,368.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13962800.00	13961800.00	13961800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,746,800.00	12,746,800.00	12,746,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,216,000.00	1,215,000.00	1,215,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4620000.00	4620000.00	4620000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,620,000.00	4,620,000.00	4,620,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,620,000.00	4,620,000.00	4,620,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,369,353,400.00	1,369,353,400.00	1,369,353,400.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,369,353,400.00	1,369,353,400.00	1,369,353,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,369,353,400.00	1,369,353,400.00	1,369,353,400.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	23.00	23.00	23.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00	13.00
620003	Үйлчлэх ажилтан	09.00	09.00	09.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

210604	Урсгал засвар	5,000,000
--------	---------------	-----------

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,076,000
131103	ЗГНХ,ЗДНХХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,076,000

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь Прокурорын тухай хуулийн 42.1 дэх заалтаар “Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэг бүхий, хараат бус, бие даасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага юм. 2024 онд 23 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж иржээ.

Эрхэм зорилго “Хараат бус, бие даасан, шударга, алагчлалгүй, үр нөлөө, бүтээмжтэй мэргэжлийн үйл ажиллагаа явуулна” гэж тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Санхүүгийн үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Татварын тухай, ХХОАТ-ын тухай гэх мэт хуулиудыг мөрдөж ажилладаг.

Тайлант онд Төсвийн тухай хуульд төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төслийн цаглаварт хугацаанд өөрчлөлт орсон. Мөн нийгмийн даатгалын тухай, Татварын тухай хуулиудад өөрчлөлтүүд орсон. Монгол Улсын ЗГХЭГ-аас Сангийн яаманд хүргүүлсэн хуралдааны тэмдэглэл зэргийг мөрдөж ажилласан байна. Тайлант онд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь Ерөнхий прокурорын тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,637.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	39,857.9	46,759.7	6,901.8
Үндсэн хөрөнгө	3,135,548.5	3,131,284.6	-4,263.9
Нийт хөрөнгө	3,175,406.4	3,178,044.3	2,637.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	262,115.3	262,115.3	0.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,175,406.4	3,178,044.3	2,637.9

Бараа материал дансны үлдэгдэл 6,901.8 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл, бусад хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө 4,263.9 мянган төгрөгөөр буурсан нь Прокурорын газрын хэрэгцээнд ашиглаж байсан 3,540,000 төгрөгийн үнийн дүн бүхий 6 ширхэг архивын шүүгээг аймгийн прокурорын газрын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хуралдааны шийдвэрээр дахин үнэлүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд саналыг Улсын Ерөнхий прокурорын газарт хүргүүлсний дагуу Улсын Ерөнхий прокурорын 2024 оны 12 дугаар сарын 20-ны А/204 дугаартай “Дахин үнэлсэн хөрөнгийг бүртгэх тухай” тушаалаар дээрх тавилгыг нийт 2,124,000 төгрөгөөр үнэлэн ирүүлснийг данс бүртгэлд бүртгэсэн.

Мөн Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 23/14 тогтоолын хоёрдугаар хавсралтын 7 дугаарт батлагдсан Зарим сумдад автомашин, төрийн байгууллагуудад дуудлагаар үйлчлэх автомашин худалдаж авах зардалд 33,000,000 /гучин гурван/ сая төгрөгийг Өвөрхангай аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/116 дугаартай захирамжаар шийдвэрлэснийг Улсын ерөнхий прокурорын газарт хүсэлт хүргүүлсний дагуу Улсын Ерөнхий прокурорын 2024 оны 05 дугаар сарын 09-ний А/76 дугаартай тушаалаар “Хөрөнгийг бүртгэлд авах тухай” шийдвэр ирүүлснийг данс бүртгэлд бүртгэсэн.

Аймгийн прокурорын газрын баланст бүртгэлтэй байсан Хюндэй-санота-7 маркийн 11-11 ӨВР улсын дугаартай тээрийн хэрэгслийг 3,000,000 төгрөгөөр дахин үнэлэн Улсын Ерөнхий прокурорын 2024 оны 02 дугаар сарын 02-ны А/33 дугаартай тушаалаар Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газарт балансаас баланст шилжүүлсэн. Тайлант хугацаанд 1,540,000 төгрөгийн үнийн дүнтэй 1 ширхэг төвийн шугамд холбогддог ус цэвэршүүлэгч төсвийн хөрөнгөөр худалдан авч үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна. Улсын Ерөнхий прокурорын 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/116 дугаартай тушаалаар компьютер 4 ширхэг, тог баригч 4 ширхэг нийт 14,031,200 төгрөгийн тоног төхөөрөмжийг аймгийн прокурорын газарт ирүүлснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу данс бүртгэлд бүртгэж авсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,369,353.4 мянган төгрөгөөр авахаар тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлээр 1,281,569.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулж 73,164.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Аймгийн Прокурорын газрын 210801 буюу байцаан шийтгэх ажиллагааны зардалд нийт 10,000.0 мянган төгрөгийг ГХУСА-ны тараах материал, шторк хийх зардал болон байцаан шийтгэх ажиллагаатай холбоотой видео контентын зардалд тус тус зарцуулсан байна. 210901 буюу Бараа үйлчилгээний бусад зардалд 12,746.8 мянган төгрөгийг албаны өдрийн видео контент, сүүдрэвч, явган хүний зам гагнах ажил болон ус цэвэршүүлэгч шүүгч хийх ажилд зарцуулсан байна. Тайлант онд хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулах босго үнэ давсан төсөвт зардал батлагдаагүй байна. Нийт 24 орон тоотой ажиллахаас тайлант онд гүйцэтгэлээр 23 орон тоотой ажиллажээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 94.6 хувьтай зарцуулагдсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70703-80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	1,354,733.4	1,281,569.0	73,164.4	94.6%
2	70703-80802-Тэтгэмж урамшуулал	4,620.0	4,620.0	00	100%
3	70703-82315-Байцаан шийтгэх ажиллагаа	10,000.0	10,000.0	0	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасан. Тайлант онд ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 24,076.0 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулах босго үнэ давсан төсөвт зардал батлагдаагүй байна.

3.5.5 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус байгууллагад хэрэгжсэн төсөл арга хэмжээ байхгүй.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан

4.Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Аймгийн Прокурорын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Цэрэндолгор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер П.Хорлоосүрэн, дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 49 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг 75 хувь гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардлын дүн 1,487,720.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 14,877.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тайлант онд дараах зардлуудыг батлагдсан төсвөөс хэмнэлттэй зарцуулжээ. Үүнд:

- ✓ Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 135,119.9 мянган төгрөг батлагдсанаас 128,157.9 мянган төгрөг зарцуулж 6,961.9 мянган төгрөгийг хэмнэсэн
- ✓ Тогтмол зардалд 66,446.8 мянган төгрөг батлагдсанаас 57,604.7 мянган төгрөг зарцуулж 8,842.0 мянган төгрөгийг хэмнэсэн
- ✓ Эд хогшил 11,360.0 мянган төгрөг батлагдсанаас 11,334.7 мянган төгрөг зарцуулж 25.3 мянган төгрөгийг хэмнэсэн
- ✓ Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийн зардалд 713.0 мянган төгрөг батлагдсанаас 378.6 мянган төгрөг зарцуулж 334.4 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 27 төрлийн 171 мэдээллийг байршуулахаас 25 төрлийн 169 мэдээллийг хугацаанд бүрэн мэдээлсэн байна. 2 төрлийн 2 мэдээллийн хугацаа болоогүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тухайн байгууллагын хувьд бусад нийцлийн асуудлын талаарх хамааралтай асуудал байхгүй байна.

4.3 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тухайн байгууллага бараа материалын тайлан санхүүгийн тайлан хоорондох уялдаа, эд хариуцагчийн тайланд тавих хяналтыг сайжруулах, байцаан шийтгэх үйл ажиллагааны зардлын жилийн төлөвлөгөө гарган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, болон хэрэгжилтийг ТАБ-д тогтоосон хугацаанд ирүүлсэн.

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын 2024 оны гуравдугаар улирлын санхүүгийн үйл ажиллагааг хамруулж завсрын аудит хийсэн. Завсрын аудитаар зөрчил гараагүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	0
Албан шаардлага	0	0	0	0	0
Зөвлөмж	1	0	1	0	100%
Нийт дүн	0	0	0	0	0

4.4 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эд хариуцагчийн гаргасан бараа материалын дэлгэрэнгүй тайланг батлагдсан маягтаар хэрхэн гаргаж тайлагнасан байдлыг анхаарч үзэх.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй

5.1 Төлбөрийн акт

Тус байгууллага дээр акт гараагүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага гараагүй.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж гараагүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулга гараагүй.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	0	0	0	0	0	0	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	0	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	0	0	0	0	0	0	0	0

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6217143681
ИЮА0059 9044094